



НИЙСЛЭЛИЙН АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН ГАЗРЫН  
ДАРГЫН ТУШААЛ

2016 оны 12 сарын 21 өдөр


Дугаар А/112

Улаанбаатар хот

Албан хаагчдыг ажилд томилж, цалин,  
цалингийн нэмэгдлийг  
тогтоох тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 33 дугаар зүйлийн 33.5, Төрийн албаны тухай хуулийн 27 дугаар зүйлийн 27.2.3, 11 дүгээр зүйлийн 11.6, Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5, Улсын Их хурлын 1995 оны 73, 2000 оны 20 дугаар тогтоол, Засгийн газрын 1995 оны 96, 2014 оны 332 дугаар тогтоол, 2011 оны 62 дугаар тогтоол, "Нийслэлийн Засаг даргын Тамгын газар, Захирагчийн ажлын албаны бүтцийг батлах тухай" Засгийн газрын 2016 оны 08 дугаар тогтоол, "Нийслэлийн Засаг даргын эрхлэх асуудлын хүрээний зарим агентлагийн зохион байгуулалтын бүтэц, орон тооны хязгаарыг батлах тухай" нийслэлийн Засаг даргын 2016 оны А/635 дугаар захирамж, "Дүрэм батлах тухай" нийслэлийн Засаг даргын 2016 оны А/831 дүгээр захирамж, газрын дүрмийн 2.5.1, 2.5.3 дахь заалтуудыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. 2016 оны 12 дугаар сарын 21-ны өдрөөс эхлэн тус газрын холбогдох албан тушаалд нэр бүхий албан тушаалтныг нэгдүгээр хавсралтаар томилсугай.
2. Нийслэлийн Аялал жуулчлалын газрын албан хаагчдын үндсэн цалин, төрийн албанд ажилласан хугацааны нэмэгдэл, төрийн жинхэнэ албан тушаалтны зэрэг дэв, ур чадварын болон бусад нэмэгдлийн хэмжээг хоёрдугаар хавсралтаар баталсугай.
3. Албан хаагчдын цалин, нэмэгдлүүдийг хоёрдугаар хавсралтад заасны дагуу тооцож олгохыг Ахлах нягтлан бодогч /Г.Цэрэннадмид/-д зөвшөөрсүгэй.
4. Албан хаагчдын хариуцаж байсан ажил болон эд хөрөнгийг хүлээлцэх комиссыг гуравдугаар хавсралтаар баталсугай.
5. Энэхүү тушаал гарсантай холбогдуулан Албан хаагчдад 2016 оны албан тушаалын үндсэн цалин, төрийн алба хаасан хугацааны болон зэрэг дэв, бусад нэмэгдэл олгох тухай" газрын даргын 2016 оны А/04 дүгээр тушаал хүчингүй болсонд тооцсугай.

ДАРГЫН АЛБАН ҮҮРГИЙГ  
ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ  Д.БАТЦУХ



E:\NAJG\Alban blanknii helvlet\Tushaal\A\16.12.21.A112.docx

1150500323


Нийслэлийн Аялал жуулчлалын газрын даргын 2016 оны 12 сарын 21 өдрийн А/112 дугаар тушаалын нэгдүгээр хавсралт



**АЖИЛД ТОМИЛОХ АЛБАН ХААГЧДЫН НЭРС**

д/д	Албан хаагчдын нэрс	Албан тушаал
1	Цэнд Энхтүвшин	Орлогч даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч
<b>Захиргааны хэлтэс</b>		
1	Дамдиндорж Ганболд	Захиргааны хэлтсийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч
2	Баярмагнай Жаргалан	Хүний нөөц, аялал жуулчлалын байгууллага хариуцсан мэргэжилтэн
3	Сайндорж Туул	Хяналт, шинжилгээ, үнэлгээ хариуцсан мэргэжилтэн
4	Машбаяр Наранцэцэг	Үйлчилгээний байгууллага, стандарт хариуцсан мэргэжилтэн /хөдөлмөрийн гэрээгээр/
5	Өлзийхүү Ариунтунгалаг	Архив, бичиг хэргийн эрхлэгч
<b>Бодлого, төлөвлөлтийн хэлтэс</b>		
1	Эрдэнэмаам Батжаргал	Бодлого, төлөвлөлтийн хэлтсийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч
2	Элээ Мөнхзул	Хөгжлийн бодлого, судалгаа хариуцсан мэргэжилтэн
3	Мижиддорж Баасандорж	Жуулчны аюулгүй байдал, сургалт хариуцсан мэргэжилтэн
4	Шараа Ундармаа	Соёлын аялал жуулчлал, салбарын хамтын ажиллагаа хариуцсан мэргэжилтэн
5	Баатарзориг Амарзаяа	Төлөвлөлт, тогтоол шийдвэрийн биелэлт хариуцсан мэргэжилтэн
6	Нармандах Алтанзаяа	Дотоодын аялал жуулчлал, бүтээгдэхүүний хөгжил хариуцсан мэргэжилтэн
<b>Мэдээлэл, сурталчилгааны хэлтэс</b>		
1	Ганболд Гансүвд	Мэдээлэл, сурталчилгааны хэлтсийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч
2	Ядамсүрэн Сарангэрэл	Хамтын ажиллагаа хариуцсан мэргэжилтэн /хөдөлмөрийн гэрээгээр/
3	Амарсанаа Эрдэнэцогт	Маркетинг, мэдээлэл хариуцсан мэргэжилтэн /жирэмсний болон амаржсаны чөлөөтэй албан хаагчийн оронд түр хөдөлмөрийн гэрээгээр/
4	Энхмөнх Даваамөнх	Олон нийтийн харилцаа хариуцсан мэргэжилтэн /жирэмсний болон амаржсаны чөлөөтэй албан хаагчийн оронд түр хөдөлмөрийн гэрээгээр/
5	Санжмятав Баяржаргал	Мэдээлэл, сурталчилгааны төвийн менежер

Нийслэлийн Аялал жуулчлалын  
газрын даргын 2016 оны 12 сарын 21  
өдрийн А/112 дугаар тушаалын  
гуравдугаар хавсралт



Ажил хүлээлцэх комисс

Комиссын дарга:	Ц.Энхтүвшин	/Орлогч дарга/
Гишүүд:	Э.Батжаргал	/Бодлого, төлөвлөлтийн хэлтсийн дарга/
	Д.Ганболд	/Захиргааны хэлтсийн дарга/
	Г.Гансүвд	/Мэдээлэл, сурталчилгааны хэлтсийн дарга/
	Д.Алтантуул	/Агентлаг хариуцсан нярав/
	Б.Жаргалан	/Хүний нөөц, аялал жуулчлалын байгууллага хариуцсан мэргэжилтэн/
Нарийн бичгийн дарга:	Ө.Ариунтунгалаг	/Архив, бичиг хэргийн эрхлэгч/